



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/03

Улаанбаатар хот

┌ “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ┐

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газрын бүтэц орон тоо,
цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.9 дэх заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II дугаар хуралдаанаас ТОГТООХ нь :

1. “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц орон тоог нэгдүгээр, цалингийн хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.


2. “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захиралтай гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д даалгасугай.

3. Батлагдсан төсөв, цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан шинэчлэн тогтоосон цалингийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын захирал (Ч.Батхуяг)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 04 сарын 05-ны өдрийн “Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж” ОНӨААТҮГ-ын бүтэц орон тоо цалингийн хэмжээг шинэчлэн батлах тухай” A/12 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ